

Хүснэгт 1. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар

№	Үндсэн чиг үүрэг	Хууль, дүрмийн зүйл, заалт	Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн нэр	
			Үндсэн хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч
1.Лифтийн ашиглалт, засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна.				
1.1	Засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх графикийг сар бүр гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	СӨХЭЗБНЗРСБДӨӨХТ Хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, ИХууль 147.6, ЛТААДүрмийн 27 дугаар зүйлийн 27.1, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.	Инженер техникийн хэсэг	Захиргаа, санхүүгийн хэсэг
1.2	Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад холбогдох стандарт, дүрэм, журмыг сурталчилж, таниулж мөрдүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллана.	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1	Инженер техникийн хэсэг	Захиргаа, санхүүгийн хэсэг
1.3	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны давтан болон өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгнө.	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1	Инженер техникийн хэсэг	Захиргаа, санхүүгийн хэсэг
1.4	Хот, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээний нэгдсэн хяналт, удирдлагын "UB ENGINEERING" цогц системд лифтийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан байгуулах.	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1	Инженер техникийн хэсэг	УБЗАА


2.Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн нэгжийн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал ажлыг гүйцэтгэх				
2.1	Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтийн магадлалыг хийж лифтийн аюулгүй ажиллагааг хангуулж ажиллана.	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.2, ЛТААДүрмийн 29 дүгээр зүйлийн 29.9.	Инженер техникийн хэсэг	Захиргаа, санхүүгийн хэсэг
2.2	Гэрээт ААНБ, СӨХ-ны хүсэлтийн дагуу лифтийн техникийн ээлжит магадлалыг хийж, лифтийн аюулгүй ажиллагааг хангуулж ажиллана.	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.2, ЛТААДүрмийн 29 дүгээр зүйлийн 29.9.	Инженер техникийн хэсэг	ХСХГ
3.Улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифт шинэчлэлтийн ажилд захиалагчийн хяналт хийх.				
3.1	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шатны засварын ажилд захиалагчийн хяналт хийнэ.	БТХуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.8, 2.9, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.3	Инженер техникийн хэсэг	УБЗАА
3.2	Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа цахилгаан шатуудын судалгааг гаргаж НЗДТГ, УБ хотын ЗАА-нд хүргүүлнэ.	СӨХЭЗБНЗРСБДӨӨХТХ уулийн 16 дугаар зүйлийн 16.6, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.3	Инженер техникийн хэсэг	УБЗАА
4.Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтад хамруулах				
4.1	Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний	ЛТААДүрмийн 27 дугаар зүйлийн 27.13,	Инженер техникийн хэсэг	“Голден рич одц” ХХК

	мэдлэг дээшлүүлэх.	мэргэжлийг	Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.4		
5.Санхүүгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах					
5.1	Газар нь өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах.		ТБОНӨТХуулийн 11 дүгээр зүйлийн 1.2, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.6	Захиргаа, санхүүгийн хэсэг	Инженер техникийн хэсэг
5.2	Байгууллагын батлуулсан төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зөв зарцуулах, өр авлагагүй ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэх.		ТТХуулийн 16 дугаар зүйлийг 16.5.5, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.6	Захиргаа, санхүүгийн хэсэг	Инженер техникийн хэсэг
5.3	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын өмч хөрөнгө, санхүүгийн тайланг хөтлөх.		НББТХуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.6	Захиргаа, санхүүгийн хэсэг	Инженер техникийн хэсэг
6.Хууль тогтоомж, нийслэлээс баримталж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөгөөр зорилго, зорилтоо тодорхойлж, түүнийгээ ханган биелүүлэх үйл ажиллагаа явуулна.					
6.1	Хууль тогтоомж, нийслэлээс баримталж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх.		Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.8	Захиргаа, санхүүгийн хэсэг	Инженер техникийн хэсэг
6.2	Жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөгөөр зорилго, зорилтоо тодорхойлж, түүнийгээ ханган биелүүлэх үйл ажиллагаа явуулах.		Газрын дүрэм (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.8	Захиргаа, санхүүгийн хэсэг	Инженер техникийн хэсэг

Алхам 4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

Хүснэгт 2: Чиг үүргийн хэрэгжилт

№	Стратегийн зорилго	Хариуцсан ажил	Биелэлт
1	Лифтийн ашиглалт, засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, бодлого хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулах	11	100%
2	Лифтийн магадлал, туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлэх	2	100%
3	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	2	80%
4	Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнийг сургах	1	100%
	Нийт	16	95%



Нэг. Захиргаа, санхүүгийн хэсгийн үндсэн чиг үүрэг

- Жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөгөөр зорилго, зорилтоо тодорхойлж, түүнийгээ ханган биелүүлэх үйл ажиллагаа явуулж, тайлан мэдээг нэгтгэн гаргах;
- Байгууллагын батлуулсан төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зөв зарцуулах, өр авлагагүй ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнд эзэмшиж ашиглах;
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын өмч хөрөнгө, санхүүгийн тайланг хөтлөх;
- Байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тайлагналт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;
- Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл гомдол, албан бичгийг хөтлөх, шийдвэрлэх.

Хоёр. Инженер техникийн хэсгийн үндсэн чиг үүрэг

- Газар нь лифтийн ашиглалт, засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх, зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулж ажиллах;
- Газар нь олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтийн магадлалыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлэх;
- Улс, орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн захиалагчийн хяналт хийх;
- Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, байнгын курсээр бэлтгэх, давтан сургах.